

Х А М Т Д А А

А С А А Я



“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК

Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

☑ Бизнесийн үйл ажиллагаа

- 05 Үйл ажиллагааны хураангуй
- 06 Зээлийн үйл ажиллагаа
- 08 Компанийн онцлох үйл явдал
- 17 Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- 18 Хүний нөөц

☑ Санхүү үйл ажиллагааны тайлан

- 21 Орлого үр дүнгийн тайлан
- 22 Санхүү байдлын тайлан
- 23 Мөнгөн гүйлгээний тайлан
- 23 Өмчийн өөрчлөлтийн тайлан
- 24 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

☑ Эрсдэлийн удирдлага

- 27 Эрсдэлийн удирдлага

☑ Компанийн засаглал

- 29 Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаа
- 29 Дотоод аудит
- 30 Компанийн бүтэц, зохион байгуулалт
- 32 Удирдлагын баг
- 33 Хувьцааны мэдээлэл




1

Бизнесийн үйл ажиллагаа

- ✓ Үйл ажиллагааны хураангуй
- ✓ Зээлийн үйл ажиллагаа
- ✓ Компанийн онцлох үйл явдал
- ✓ Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- ✓ Хүний нөөц

2023 ОНЫ III УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2023 оны III улирлын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал.



ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2023 оны III улиралд нийт харилцагч нартаа 168 тэрбум төгрөгийн дүнтэй 487 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.

Түүнчлэн 2023 оны III улирлын зээлийн

голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн улиралтай харьцуулахад бүртгэлтэй харилцагчдын тоо 8.8%, олгосон зээлийн дүн 132.5%, зээлийн багц 101.9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Гэрээт харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




Бүртгэлтэй харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




Зээлийн багц

/Тэрбум төгрөг/




Харилцагчид байршлаар

байршлаар




Олгосон зээлийн дүн

/Тэрбум төгрөг/



Олгосон зээлийн тоо

/Мянган зээл/




Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2023 оны III улирлын байдлаар зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 4.9%-д хүрч өмнөх оны мөн үеэс 15.6%-иар буурсан

бол зээлийн эрсдэлийн сангийн нөөцийг 5.7 тэрбум төгрөгт хүргэж ажиллалаа.

Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь



GOLDEN SPONSOR




ЛЭНДМН НЬ "FRONTIER FINTECH SUMMIT 2023" АРГА ХЭМЖЭЭНИЙ "GOLDEN SPONSOR"-ООР АЖИЛЛАЛАА

Монголын Финтекийн Холбооноос 2023 оны 9 дүгээр сарын 18, 19 -ний өдрүүдэд "Frontier Fintech Summit 2023" арга хэмжээг зохион байгуулсан ба ЛэндМН нь Монголын хамгийн анхны Финтек компанийн хувьд өөрсдийн туршлага, цаашдын алсын хараа зорилго хуваалцахын сацуу Дэд захирал Д.Баасандорж "Финтекийн ирээдүй ба инновац" сэдвээр илтгэл танилцуулан

ивээн тэтгэгч байгууллагаар хамтран ажиллалаа.

Энэхүү арга хэмжээ нь Монголын финтек салбарын гол төлөөллүүд, олон улсын туршлагатай экспертүүдийг урьж оролцуулан өнөөгийн финтекийн салбарт тренд болж буй чухал сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлж, туршлага хуваалцсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.



“ЛЭНД БОНД”-ЫН ₮5 ТЭРБУМЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙГДЛЭЭ

“ЛэндМН ББСБ” ХК нь 2021 оны 06 дугаар сард олон нийтээс 2 жилийн хугацаатай татан төвлөрүүлсэн “ЛэндБонд”-ын үндсэн болон хүүгийн төлбөрийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансанд байршуулж дууслаа.

Дижитал хөрөнгө оруулалт “ЛэндБонд”-ыг олон нийтэд санал болгож, 5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр нийт 504 хөрөнгө оруулагч нараас захиалга хүлээн

авч зорьсон үнийн дүнгээс даруй 51.6%-иар давж биелж байсан юм.

ЛэндМН нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагч нартаа шинэлэг, бүтээгдэхүүнүүдийг таатай нөхцөлөөр санал болгож ажилласаар ирсэн ба хөрөнгө оруулагч нарынхаа итгэлийг хүлээн “ЛэндБонд”-ын хүүгийн төлбөрийг хагас жил тутам хугацаандаа байршуулж ажиллалаа.

“ЛЭНДМН ББСБ” ХК НЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, НОГООН БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР “НОМАДС АГРИТЕК ИННОВЭЙШНС” ХХК-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын тогтвортой санхүүжилт /ТОС/ холбооны гишүүн бөгөөд 2022 оноос хойш Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 5 дугаар сард “Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоо”-ны гишүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох санамж бичиг байгуулсан билээ.

Уг санамж бичгийн хүрээнд ногоон бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Номадс агритек инновэйшнс” ХХК хамтран ажиллах ба хамтын ажиллагааны хүрээнд уг компанийн санаачлан зохион бүтээсэн “Фини” аппликейшний нээлтийн арга хэмжээнд ЛэндМН нь газар тариалангийн бизнес эрхлэгч нарт

10 сая төгрөг хүртэл зээлийг хүүгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох талаар танилцууллаа.

ЛэндМН нь Монгол улсын анхны финтек компани бөгөөд 2017 онд иргэдэд барьцаагүй, дижитал зээлийг олгож байсан ба өнөөдрийг хүртэл Улаанбаатар хотод нэг салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа хэдий ч 1.1 сая харилцагчдад хүрч үйлчилж байна.

Өнөөдрийг хүртэл бий болгосон санхүүгийн технологийн шийдэл, туршлагадаа тулгуурлан ЛэндМН аппликейшнээр дамжуулан бизнес эрхлэгч нарт зориулсан уян хатан нөхцөлтэй бизнесийн зээл бүтээгдэхүүн гаргахаар зорин ажиллаж байна.



LENDMN АППЛИКЕЙШНД МЕРЧАНТУУДЫН МЭДЭЭЛЭЛ БАЙРШЛАА

ЛэндМН-ийн худалдан авалтын зээлийг үйлчилгээг авах боломжтой хамтран ажиллагч байгууллагуудын мэдээллийг LendMN аппликейшний “Нүүр” хэсгээс харах боломжтой боллоо. LendMN-ийн худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн болох LendPay, FlexiPay-ээр 60 хоногийн хугацаанд Урьдчилгаагүй, Хүүгүй, Шимтгэлгүй худалдан авалт хийгээрэй.



БАТАЛГААЖУУЛАХ БОЛОМЖТОЙ БҮХ ДАНСНЫ ХУУЛГАА ИЛГЭЭДЭГ БОЛЛОО

Та өөрийн нэр дээрх тогтмол орлого хүлээн авдаг, LendMN аппликейшн дээр баталгаажуулах боломжтой БҮХ ДАНСНЫ ХУУЛГАА илгээгээд зээлийн эрхээ дахин тогтоолгох, нэмэгдүүлэх боломжтой болсон.



ХӨРӨНГӨТӨН

Хөрөнгө оруулалтын хаалттай форум

Шангри-Ла зочид буудал

2023.08.11

www.hurungutun.mn



Хөрөнгө оруулагчдын “Хөрөнгөтөн” хаалттай форумд өндөр өгөөжтэй, уян хатан нөхцөлтэй, найдвартай санхүүгийн хэрэгслүүдэд хэрхэн хөрөнгө оруулж, хөрөнгөө хур арвижуулах

туршлагаасаа хуваалцаж, хүрэлцэн ирсэн хөрөнгөтнүүдэд ЛэндМН бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулан амжилттай хамтран ажиллалаа.

“ХӨРӨНГӨТӨН” ФОРУМД “ЛЭНДМН ББСБ” ХК ОНЦЛОХ ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛЖ, ХАМТРАН АЖИЛЛАЛАА

Эдийн засагт үлэмж нөлөөтэй өндөр дүнгээр хөрөнгө оруулагчдын “Хөрөнгөтөн” форум дээр санхүү, үл хөдлөх, технологийн салбарын нийт 12 төсөл танилцуулагддаг. Финтек буюу технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг Монголчуудад анх удаа нэвтрүүлсэн “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дэд захирал Д.Баасандорж 2023 оны “Хөрөнгөтөн” хаалттай форум дээр онцлох төслөө танилцууллаа.

Тус үйл ажиллагааны үеэр “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дэд захирал Д.Баасандорж хэлэхдээ:

“ЛэндМН өнөөдрийг хүртэл 170 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалтыг нээлттэй болон хаалттай санхүүгийн хэрэгслүүдээр татан төвлөрүүлсэн. Бид хөрөнгө оруулагчдадаа өгөөж, ногдол ашгийг цаг хугацаандаа олгодог мэргэжлийн жишгийг тогтоосон төдийгүй 2023 оны хагас жилийн цэвэр ашиг маань өмнөх жилийн мөн үеэс 390.4 хувиар нэмэгдэж, үсрэнгүй өсөлт гаргаад байна.

Энэхүү санхүүгийн технологийн загвар буюу хиймэл оюун ухаан дээр суурилсан кредит скорингийн зохистой тооцооллыг зүүн өмнөд Азийн орнуудад экспорт хийж, Монгол залуусын оюуны бүтээлийг дэлхий ашигладаг боллоо” хэмээн хэллээ.





Лэнд Бонд

Нийт үнийн дүн 9 тэрбум ₮	Хүү төлөлт УЛИРАЛ БҮР
Нэрлэсэн үнэ 100,000₮	Хугацаа 24 сар
Хүү /жилийн/ 18%	Захиалга авах хугацаа 2023.09.04-2023.09.08

Participating companies: RHINOS, lendmn, UIZI & Co, TENER CAPITAL.

“ЛЭНД БОНД”-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН “ЦАН” ЦОХИЖ, 9 ТЭРБУМ ТӨГРӨГ АМЖИЛТТАЙ БОСГОЛОО

ЛэндМН-ийн итгэл даасан 4 дэх удаагийн нээлттэй “Лэнд Бонд” нь 24 сарын хугацаатай, жилийн 18%-ийн хүүтэй, улирал тутам хүү төлөгдөх, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 90,000 ширхэг өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх албан ёсны хүндэтгэлийн цан цохих ёслолын үйл ажиллагаа Монголын Хөрөнгийн Биржид амжилттай боллоо.

“Лэнд Бонд” -ын анхдагч зах зээлийн арилжаа 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр 10 цагт цан цохиж нээгдсэн даруй нийт 89 хөрөнгө оруулагчдаас 9.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, амжилттай хаагдлаа.

“Лэнд Бонд”-д гаргах ажилд хамтран ажиллаж амжилттай зохион байгуулсан

мэргэжлийн оролцогч талууд болох андеррайтер “Райнос инвестмент ҮЦК”ХХК, “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК, “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК, “Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН, “Нийслэл Аудит” ХХК нартаа баярлалаа.

“ЛэндМН ББСБ” ХК-д итгэл хүлээлгэсэн “Санхүүгийн Зохицуулах Хороо” болон “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.


Бид өөрсдийн тогтоосон жишгийн дагуу хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж, уламжлалт болон шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэвшилтэт технологи дээр тулгуурлан шинэлэг байдлаар харилцагч нартаа хүргэж, санхүүгийн хүртээмжийг

нэмэгдүүлэн санхүүгийн салбарыг манлайлан ажилласаар байх болно.

Харилцагч та бүхэн “ЛэндБонд”-ын анхдагч зах зээлийн арилжаанд оролцож чадаагүй бол Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан ЛЭНД БОНДЫН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГААР

бондоо худалдах, худалдан авах бүрэн боломжтой.

Бидэнтэй үргэлж хамт байж, бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилладаг “Лэнд Бонд”-д хөрөнгө оруулсан нийт хөрөнгө оруулагч нартаа баярлалаа.





“АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЕ” АЯНД НЭГДЛЭЭ

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос нийгмийн хариуцлагын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЕ” цусаа хандивлах аяныг 5 дахь жилдээ 2023 оны 9-р сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Тус аянд өнгөрсөн 4 жилийн хугацаанд Холбооны гишүүн 71 ББСБ-ын 910 ажилтан, албан хаагчид оролцож 3,000 хүнд АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЖЭЭ.

“Амьдрал бэлэглэе” цусаа хандивлах аянд ЛэндМН-ийн залуус ч жил бүр идэвхтэй оролцож, энэхүү их үйлсэд өөрсдийн хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ.

Энэ жилийн энэхүү үйл ажиллагааг дэмжин цусаа хандивласан Лэндийнхээ болон салбарынхаа нийт залуустаа БАЯРЛАЛАА.

Сайн үйлс бүхэн түм, бумаар арвижин дэлгэрэх болтугай.

КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



ЛэндМН нь санхүүгийн хүртээмжтэй байдлыг хүн бүрд хүргэх зорилгоор: Технологийн дэвшлийг ашиглан Улаанбаатар хотод 1 салбартайгаар, харилцагчдадаа цахимаар зээлийн үйлчилгээг үзүүлэн Монгол улсын өнцөг булан бүрд хүрч үйлчилж байна.

Харилцагч бүрийн санхүүгийн асуудлыг шийдэхийн тулд зөвхөн тогтмол цалингийн орлоготой харилцагчдад зээл олгох бус тогтмол орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 15 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2023 оны III улирлын турш нийт 79,634 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар 79,634 харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 99.37%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэж ажилласан байна.




2023 оны III улиралд нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа 3 цаг зарцуулдаг гэж үзвэл бид цахимаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр 70 мянган харилцагчийн зээл авахад зарцуулах 211 мянган цаг буюу 24 жилтэй тэнцэх хэмжээний хугацааг хэмнэх боломжийг олгожээ.



Нэг удаагийн зээл олголтод дунджаар 15 хуудас цаас зарцуулдаг. Бид тайлант үед 1.5 сая удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор 112 тонн цаас хэмнэж 1,800 ширхэг мод аварчээ.

Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн 465 тэрбум төгрөгийн эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.

Манай хамт олон



ХҮНИЙ НӨӨЦ



2


Санхүү үйл ажиллагааны тайлан

- ☑ Орлого үр дүнгийн тайлан
- ☑ Санхүү байдлын тайлан
- ☑ Мөнгөн гүйлгээний тайлан
- ☑ Өмчийн өөрчлөлтийн тайлан
- ☑ Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2023 оны III улирлын байдлаарх орлогын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 12.5 тэрбум төгрөгт хүрч 153.6%-иар, цэвэр ашиг 4.7 тэрбум төгрөгт хүрч 3 дахин өссөн байна.

2023 оны III улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 103.9 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 99.8%-иар өссөн бол цэвэр зээлийн багц 104.6%-иар өсч 94.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2021.III	2022.III	2023.III
Нийт орлого	3.6	4.9	12.5
Хүүгийн зардал	(0.6)	(1.2)	(2.7)
Цэвэр орлого	3.0	3.7	9.8
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(0.4)	(0.7)	(1.1)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.4)	(0.4)	(1.1)
Үйл ажиллагааны цэвэр орлого	2.2	2.6	7.7
Удирдлагын болон ҮА-ны зардал	(1.2)	(1.2)	(1.6)
Татварын өмнөх ашиг	1.1	1.5	6.1
Татварын зардал	(0.1)	(0.2)	(1.4)
Цэвэр ашиг	1.0	1.3	4.7

Санхүү байдлын тайлан /Аудитлагдаагүй/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2021.III	2022.III	2023.III
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	5.2	2.3	4.8
Зээлийн багц (цэвэр)	30.2	46.3	94.7
Бусад хөрөнгө	1.4	2.3	3.3
Үндсэн хөрөнгө	0.8	0.7	0.7
Биет бус хөрөнгө	0.2	0.4	0.4
Нийт хөрөнгө	37.7	52.0	103.9

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/

Өр төлбөр	2021.III	2022.III	2023.III
Эх үүсвэр	14.0	24.6	57.4
Бусад өглөг	2.0	2.9	7.9
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Эздийн өмчийн дүн	18.9	21.7	35.9
Хувьцаат капитал	8.8	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	10.1	13.2	27.4
Нийт өр төлбөр болон эздийн өмч	37.7	52.0	103.9

Мөнгөн гүйлгээний тайлан /Аудитлагдаагүй/

Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2021.III	2022.III	2023.III
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1.0)	(3.1)	(6.5)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.1)	(0.1)	(0.0)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	4.5	3.5	3.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	3.5	0.3	(2.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.7	2.0	7.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5.2	2.3	4.8

Өмчийн өөрчлөлтийн тайлан /Аудитлагдаагүй/

Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Хоёрдогч өглөг	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2021.12.31-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)	2.8	15.7	27.0
Тайлант үеийн цэвэр ашиг				3.7	
Ногдол ашиг					
2023.03.31-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)	2.8	19.4	30.7
Тайлант үеийн цэвэр ашиг				4.6	
Ногдол ашиг				(1.3)	
2023.06.30-ний өдрөөр байдлаар	10.8	(2.3)	2.8	22.7	34.0
Тайлант үеийн цэвэр ашиг				4.7	
Ногдол ашиг					
2023.09.30-ний өдрийн байдлаар	10.8	(2.3)	2.8	27.4	38.7

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар 2.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 4.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах

хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 110.7%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2021.III	2022.III	2023.III
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	48.8%	38.1%	30.6%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	56.1%	43.1%	33.0%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	50.1%	41.7%	34.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	32.2%	8.5%	8.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	(11.6%)	(19.7%)	(30.0%)
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	36.9%	45.8%	78.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	27.5%	42.4%	36.6%

Х А М Т Д А А

А С А А Я А



Эрсдэлийн удирдлага

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч болон харилцагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан харилцагч болоод бизнесийн орчинд нөлөөлж болох эрсдэлийг олон улсын аргачлалын дагуу хянаж Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ.

ЛэндМН нь Монгол улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийг үйл ажиллагаандаа нийцүүлснээр санхүүгийн үнэн зөв тайлагнал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна.

Монгол улсын хэмжээнд шинээр хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомж түүнийг даган гарсан Зохицуулагч байгууллагын тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн компанийн холбогдох дотоод журмуудад өөрчлөлт оруулан шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж эхэлсэн.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар

хүлээсэн үүргийхээ хүрээнд Харилцагчийг таньж мэдэх, эрсдэлийг үнэлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол үйл ажиллагаандаа хэрэгжүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаа.

Эрсдэл, хянан нийцүүлэлтийн нэгж нь компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, холбогдох дүрэм журамд нийцүүлэх, харилцагч нарын эрх ашгийг хамгаалах ажлыг удирдан зохион байгуулдаг бөгөөд 2023 оны III Улиралд Цахим орчинд залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн өөрийн байгууллагын дотоод журам болон ЛэндМН аппликейшнд холбогдох өөрчлөлтийг оруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Санхүүгийн Зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 434 дүгээр тогтоолоор “Итгэлцлийн үйлчилгээний журам” баталж, 09 дүгээр сарын 26-ны өдөр Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-ууд дагаж мөрдөх, үйл ажиллагаандаа нийцүүлэх үүрэгтэй бөгөөд Хууль, хянан нийцүүлэлтийн албанаас өөрийн компанийн Итгэлцлийн үйлчилгээний нөхцөлийг уг журамтай нийцүүлэн хуулийн дүгнэлт гарган холбогдох өөрчлөлтийг оруулах зөвлөмж мөн хүргүүлээ.

4

Компанийн засаглал

- Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үйл ажиллагаа
- Дотоод аудит
- Компанийн бүтэц, зохион байгуулалт
- Удирдлагын баг
- Хувьцааны мэдээлэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2023 оны III улиралд 1 удаа ээлжит хурал, 1 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 2 тогтоол гаргаж, компанийн зүгээс нийтэд санал болгон гаргасан үнэт цаас буюу Лэнд Бондын нөхцөлийг тогтоож, мөн Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын

хэрэгжилтийн хүрээнд компанид мөрдөгдөх журмуудыг батлахтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэн ажилласан байна. ЛэндМН нь ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлсэн болно.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэлийн удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2023 оны III улиралд тус бүрийн чиг үүргийн дагуу үйл

ажиллагаа явуулж, ЛэндМН-ийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагааны мэдээлэлтэй тухай бүр танилцсан бөгөөд ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, дотоод хяналт, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, шаардлагатай санал, зөвлөмж, дүгнэлт гарган ажиллалаа.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛэндМН нь Хамгаалалтын гурван бүс / Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж,


тасралтгүй сайжруулан ажиллаж байна. Компанийн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог схемээр харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн

баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнах, Гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН УДИРДЛАГЫН БАГ



Ц.Ууганбаяр
“ЛэндМН ББСБ” ХК
Гүйцэтгэх захирал

Банк, санхүүгийн салбарт 15 жил,
“АНД Глобал” Пти.Лтд-д
7 дахь жилдээ ажиллаж байна.



К.Мадоно
“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхийлөгч

Банк, санхүүгийн салбарт 41 жил,
“АНД Глобал” Пти.Лтд-д
5 дахь жилдээ ажиллаж байна



Д.Баасандорж
“ЛэндМН ББСБ” ХК
Бизнес хөгжлийн газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 5 жил,
“АНД Глобал” Пти.Лтд-д 3 дахь
жилдээ ажиллаж байна.



М.Түвшинжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 24 жил,
“ЛэндМН ББСБ” ХК-д 7 дахь
жилдээ ажиллаж байна.




Г.Золжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхий нягтлан бодогч

Банк, санхүүгийн салбарт 16 жил,
“ЛэндМН ББСБ” ХК-д 3 дахь
жилдээ ажиллаж байна.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Лэнд хувьцааны мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2023 онд :

2023 оны III улирлын байдлаар Lend хувьцааны ханш оны эхнээс 59.0%-иар өсч нэгж хувьцаа 48.0 төгрөгт хүрч хаагдсан байна.

- Нийт арилжаалагдсан ширхэг - 17.1 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн - 649.8 сая төгрөг



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2023 оны III улирлын санхүү, үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн:
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр